



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/404

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2022 оны 05 сарын 31-ний өдрийн 73 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГАОНӨГ/202212025 дугаартай Боловсролын салбарыг цахимжуулах, платформ нэвтрүүлэх (өгөгдлийн сантай сервер компьютер цахим сургалтын агуулга хийх) эрхийг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т олгосугай

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл) Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

